



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 12 сарын 11 өдөр

Дугаар 483

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Өдрийн эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан журмыг мөрдөж ажиллахыг эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.
3. “Өдрийн эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /О.Баяр/-т, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Э.Оюунсүрэн/-т тус тус даалгасугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2006 оны “Журам батлах тухай” 279 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Өдрийн эмчилгээ хийх журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙДЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР

081833

Эрүүл мэнд, спортын сайдын  
2015 оны 12 сарын 11 өдрийн  
483 дугаар тушаалын хавсралт

УХА0033 9087443

## ӨДРИЙН ЭМЧИЛГЭЭ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

### Нэг. Өдрийн эмчилгээ, үйлчилгээний зохион байгуулалт

1. Энэхүү журмын зорилго нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, эмнэлгийн шаардлагагүй хэвтэлтийг багасгах, орны хүлээгдлийг бууруулах, өвчтний сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд оршино.
2. Энэхүү журмаар төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэг, амбулатори, амаржих газар, клиник, сум дундын эмнэлэг, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд хийгдэх өдрийн эмчилгээ, үйлчилгээг зохицуулна.
3. Өдрийн эмчилгээ, үйлчилгээ гэдэгт үйлчлүүлэгчийг эмнэлэгт хонуулахгүйгээр үзүүлэх мэс заслын болон мэс заслын бус эмнэлгийн тусламж, үйлчилгээг хамааруулна.
4. Өдрийн эмчилгээ, үйлчилгээ нь хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнд хамаарахгүй ба хоол, цагаан хэрэглэлээр хангахгүй.
5. Өдрийн эмчилгээ, үйлчилгээг эрүүл мэндийн даатгал болон улсын төсвөөс санхүүжүүлэх, төлбөртэй үзүүлэх асуудлыг холбогдох журмаар зохицуулна.
6. Өдрийн эмчилгээ, үйлчилгээнд хамрагдах зөвшөөрлийг үйлчлүүлэгч, түүний асран хамгаалагчаас бичгээр авч "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ"-ний журмаар батлагдсан маягтанд бөглөж, өвчний түүхэнд хавсаргасан байна.
7. Өдрийн эмчилгээ, үйлчилгээнд амбулаторийн үзлэг зөвлөгөө, жижиг мэс ажилбар, эмчийн бичсэн жороор гэрээр ууж хэрэглэх эм, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, эдийн шинжилгээнээс бусад оношилгоо, шинжилгээ хамаарахгүй.
8. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт үзүүлэх өдрийн эмчилгээг 0-5 насны хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай болон нийгмийн халамж, дэмжлэг шаардлагатай иргэнд үзүүлнэ.
9. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт үзүүлэх оношийн ангилалд хамаарах өвчний үед эмнэлгийн мэргэжилтний шууд хяналтанд курсээр болон схемээр ууж хэрэглэх эм, тарилга, сэргээн засах эмчилгээ хамаарна.

10. Уламжлалт, хөнгөвчлөх эмчилгээний оношийн заалтыг холбогдох журмаар зохицуулна.
11. Үйлчлүүлэгчийн өдрийн эмчилгээ хийлгэх өдөр, дараалал, цаг товлох, эмчилгээ үргэлжлэх хугацааг зохицуулах асуудлыг амбулаторийн эрхлэгч, эрүүл мэндийн төвийн дарга хариуцна.

### **Хоёр. Өдрийн эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх орчин нөхцөл**

1. Өдрийн эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх өрөө нь тухайн эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагааны стандартын шаардлага хангасан байна.
2. Өдрөөр эмчилгээ, үйлчилгээ үзүүлэхдээ Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан халдварын сэргийлэлт, хяналтын журмыг баримтлана.
3. Өдрийн эмчилгээний тусламж, үйлчилгээнд амбулаторийн эрхлэгч, эрүүл мэндийн төвийн дарга, сувилгааны албаны дарга, эмчилгээ эрхэлсэн орлогч дарга хяналт тавина.
4. Өдрийн эмчилгээ, үйлчилгээнд амбулаторийн болон тасгийн эмч нар сэлгэн ажиллах зарчмаар ажиллаж, илгээх бичиг үйлдсэн эмч өөрөө хариуцан үзэж, өвчний түүхийг хөтөлнө.
5. Өдрийн эмчилгээнд орон тооны сувилагч сувилахуйн тусламж, үйлчилгээг өдрийн эмчилгээ, сувилгааны хэсэгт үзүүлэх удирдамжийн дагуу ажиллана.
6. Өдрийн эмчилгээний сувилагчид 1 өдөрт 10-аас илүүгүй үйлчлүүлэгч ногдохоор тооцож ажиллана.
7. Өдрийн эмчилгээ, үйлчилгээг холбогдох эмнэлзүйн стандарт, удирдамжийн дагуу гүйцэтгэж, өвчний түүх, сувилгаа, сэргээн засах эмчилгээ, үйлчилгээний картанд тэмдэглэнэ.
8. Хорт хавдрын үеийн хими эмчилгээг тухайн өвчтөнд курсээр давтан хийхдээ эхний нээсэн өвчний түүхийг үргэлжлүүлэн хөтөлж болно.
9. Эмчилгээ, үйлчилгээний нэг удаад үргэлжлэх хугацаа нь 4 цагаас хэтрэхгүй байна.
10. Эмчилгээний дараа өвчтний биеийн байдлыг асууж лавлах, зөвлөгөө өгөх, холбоо барихад зориулсан утас, цахим сүлжээгээр хангасан байна.
11. Өдрийн эмчилгээ, үйлчилгээний өрөө нь 18 мкв-аас доошгүй талбайтай, эмийн шүүгээ, сувилагчийн тэргэнцэр, нэг өрөөнд 4-өөс илүүгүй эмчилгээний ор, угаалтууртай байна.
12. Өдрийн эмчилгээний өрөөг яаралтай тусламжийн эм, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангасан байна.
13. Үйлчлүүлэгчид эмнэлгийн хуудсыг эмчлүүлсэн хоногоор бодож, өвчний түүхийг хааснаас хойш ажлын 5 хоногт багтаан олгоно.

14. Эрүүл мэндийн байгууллага нь өдрийн эмчилгээ, үйлчилгээний зохицуулалтыг чирэгдэлгүй, эмнэлгийн мэргэжилтний ачааллыг оновчтой зохион байгуулсан, бусад тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар, аюулгүй байдлыг алдагдуулахгүйгээр зохицуулах дотоод журам, ажлын хуваарь гаргаж мөрдүүлнэ.
15. Өдрөөр мэс засал эмчилгээ хийх тохиолдолд хагалгааны өрөөтэй байна.
16. Мэс заслын тусламж, үйлчилгээ үзүүлэх мэргэшсэн хүний нөөц, стандартад заасан эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног, төхөөрөмжөөр хангагдсан байна.
17. Мэс заслын тусламж, үйлчилгээг оношилгоо, эмчилгээний болон бусад батлагдсан стандарт технологи, эмнэлзүйн удирдамжийн дагуу чанартай үзүүлнэ.
18. Мэдээгүйжүүлгийг батлагдсан стандарт, удирдамжийн дагуу гүйцэтгэж, өвчтөний биеийн байдалд хяналт тавин, өвчний түүхэнд тэмдэглэнэ.
19. Мэс заслаар авагдсан зүйлсийг эд, эсийн шинжилгээнд өгч хариуг өвчний түүхэнд хавсарган тэмдэглэнэ.

### **Гурав. Өдрийн эмчилгээ, үйлчилгээнд хамруулах заалт**

Өдрийн эмчилгээ, үйлчилгээнд эмнэлгийн мэргэжилтний шууд хяналтанд уух эм, тарилга, өдрийн мэс засал, хэвлийн диалез, гемодиалез, хими, туяа, лазер эмчилгээ болон уламжлалт, сэргээн засах тусламж, үйлчилгээ хамаарна. Дараах шаардлагыг үндэслэн өдрийн эмчилгээнд хамруулна. Үүнд:

1. Өвчтөний онош шинжилгээ, эмнэлзүйгээр батлагдсан байх,
2. Өвчтөний өвчин эмгэг нь амь насанд аюул учруулахааргүй байх,
3. Өдрөөр хийгдэх эмчилгээ, үйлчилгээний дараа ажиглалтын хугацаа дуусахад өвчтөн гэртээ эргэн харих бүрэн чадамжтай байх,
4. Бага насны хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд эмчилгээний явцад байнгын асран халамжлагчтай байх,
5. Өвчтөн хэвтрийн дэглэм сахих заалтгүй байх,
6. Өвчтөн 24 цагийн дотор эмнэлэгт давтан үзүүлэх шаардлагагүй байх,
7. Мөн 24 цагийн туршид мэргэжлийн сувилахуйн тусламж, үйлчилгээ авах шаардлагагүй байх,
8. Тухайн өвчтөнд үзүүлэх өдрийн эмчилгээ, үйлчилгээний давтамж нь 10 өдрөөс хэтрэхгүй, улиралд нэгээс илүүгүй байх,
9. Өвчтөн болон асран хамгаалагч нь холбоо барих утастай байх.

## Дөрөв. Өдрийн эмчилгээ, үйлчилгээнд хамрагдахгүй заалт

Эмчийн бичсэн жороор гэрээр ууж хэрэглэх эм, хүүхдийн мэс засал, өвчний түүх нээх шаардлагагүй амбулатороор хийх жижиг мэс ажилбар нь өдрийн эмчилгээ, үйлчилгээнд хамаарахгүй.

Дараах тохиолдолд өдрийн эмчилгээ, үйлчилгээнд хамруулахгүйгээр тусламж, үйлчилгээний бусад тохирох хэлбэрийг сонгон үйлчилнэ. Үүнд:

1. Эмчийн хяналтанд 24 цаг байх шаардлагатай үед,
2. Эмчилгээ, үйлчилгээг өдөрт нэгээс олон удаа давтан эмчилгээ, цагийн тариа хийлгэх шаардлагатай үед,
3. Хэвтрийн дэглэм сахих шаардлагатай, өвчтөний биеийн байдал хүнд, өвчний явц хүндрэх тохиолдолд,
4. Шөнийн цагаар дахидаг, хурц өвдөлт өгдөг өвчний үед,
5. Эмчилгээний хоолны дэглэм онцгой шаардлагатай,
6. Амбулаториор боолт хийх, шарх цэгцлэх, жижиг оёдол тавих,
7. Эмчийн жороор эмийг гэрээр уух боломжтой, өвчтөний биеийн байдал хөнгөн бол хамрагдахгүй.

### Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн өдрийн эмчилгээнд хамаарах оношийн ангилал

хүснэгт 1

№	Бүлгийн нэр	ОХБ-ийн дугаар	Онош	Өвчний олон улсын 10 ангилал
1	Мэдрэлийн эмгэг	6	Ердийн мигрень, толгойн өвдөлт	G43.0, G44
2	Чих хамар хоолойн эмгэг	16	Цочмог болон архаг фарингит, тонзилит, трахейт, ларингит, бронхит	J02-J08, J20 J30-J32 J35, J37
3	Амьсгалын замын эмгэг	19, 20	Үүсгэгч нь тодорхой томуугийн болон бактерт пневмони /шинжилгээгээр оношийг баталсан байх/	J10-J11, J13, J15, J20-J21
4	Зүрх судасны тогтолцооны эмгэг	31	Артерийн даралт ихсэх өвчний хөнгөн хэлбэр	I10- I15
5	Бөөр, шээсний замын тогтолцооны эмгэг	82	Архаг пиелонефрит, хурц болон архаг цистит	N11, N30

6	Хоол боловсруулах замын эмгэг	49, 53, 59	Гастрит, дуоденит, диспепси, Халдварт бус гастроэнтерит ба колит, Суулгалт өвчин	K29, K30, K52.9
7	Артрит, холбох эдийн эмгэг	69	Хэрлэг төст артрит	M05, M06
			Артроз	M15-M18

**Нэгдсэн эмнэлэг, БОЭТ, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвд үзүүлэх өдрийн эмчилгээнд хамаарах оношийн ангилал**

хүснэгт 2

№	Оношийн бүлэг	ОХБ-ийн дугаар	Онош	Өвчний олон улсын 10 ангилал
1.	Уналт, таталт, эпилепсийн байдал	5	Энгийн хэсэгчилсэн уналт бүхий голомтот (хэсэгчилсэн) (парциаль) шинж тэмдгийн эпилепси ба эпилепсийн хамшинж	G40, G41
2.			Ухамсарт ухаан үл өөрчлөгдөх уналтын дайрал, Хөнгөн явцтай түгээмэл идиопат эпилепси ба эпилепсийн хамшинж	
3.			Бага уналт, тодорхойгүй (их уналт хавсраагүй)	
4.	Мигрень ба толгойн өвдөлт	6	Мигрень	G43
5.			Толгой өвдөх бусад хамшинж	G44
6.			Тархины цус багасах дайрал ба түүнд хамаарах хамшинжүүд	G45
7.			Цус хомсрох дайрал	G
8.	Мэдрэлийн тогтолцооны бусад эмгэг	7	Мэдрэлийн ёзоор ба сүлжээний эмгэг, дарагдал	G54, G55
9.			Мөчдийн болон бусад невропати	G56-G62
10.			Гемиплегия, Саажилтын хам шинж	G81-83
11.	Нүдний эмгэг	9, 12, 13	Глауком	H40
12.			Өвдөг ба халазион	H00
13.			Зовхины үрэвсэл, эмгэг	H01- H03

14.			Нулимсны эрхтэний эмгэг	H04
15.			Коньюктивит	H10
16.			Рефракци ба аккомодацийн эмгэг, Анопсигаас улбаалсан амблиопи, Диплопи, Харах талбайн согог, хараа муудах	H52-H54
17.	Чих хамар хоолойн өвчнүүд	15, 17	Гадна чихний өвчнүүд	H60-H62
18.			Дунд чихний үрэвсэл, Сонсголын [Евстахийн] гуурсны үрэвсэл ба бөглөрөл, Мастоидит	H65-H68
19.			Хэнгэргийн холестеатом, Хэнгэргэн хальс цоорох, Мирингит	H70-H73
20.			Тэнцвэрийн үйл ажиллагааны хямрал	H81
21.			Дуу дамжуулах ба хүлээн авах хэлбэрийн сонсгол бууралт	H90
22.			Цочмог ба архаг ларингит, фарингит, тонзилит трахеит, Харшилт ринит, хамрын ур, архаг синусит	J04-J05, J30-J37
23.	Амьсгалын замын үрэвсэлт өвчнүүд	19,20	Бронхит, бронхиолит,	J20, J21, J40-J42
24.			Уушги тоосжих, Пневмонит	J60-J67
25.			Бактерт болон шимэгчийн пневмони	J13-J19
26.			Аспирацийн пневмони, пневмонит	J69
27.	Багтраа багтраат байдал	21	Багтраа /бөглөрөлтгүй/	J45
28.			Бронхэктази	J47
29.	Венийн судасны эмгэгүүд,	28	Доод мөчний венийн бүдүүрэл /идээт үрэвсэлгүй/	I83
30.			Шамбарам /хүндрэлгүй/	I84
31.	Атеро склероз	30	Мөчний артерийн атеросклероз, хөгшрөлийн атеросклероз	I70
32.	Даралт ихсэх өвчнүүд,	31	Анхдагч даралт ихсэх өвчин	I10
33.			Зүрхний дутмагшилгүй артерийн даралт ихсэх өвчин, Бөөрний гаралтай артерийн даралт ихсэх өвчин /зүрх, бөөрний дутагдалгүй/	I11- I15
34.	ОН хавх лаг ын эмгэг	32	Хэрлэгийн гаралтай хоёр хавтаст, 3 хавтаст, гол судасны хавхлагын өвчнүүд	I05-I07

35.			Хоёр хавтаст, гурван хавтаст, гол судасны хавхлагын хэрлэгийн бус гаралтай эмгэгүүд	I34-I36
36.			Эндокардит, гэмтсэн хавхлагыг тодорхойлоогүй	I38
37.	Цээжний бах,	34	Стенокардия /хүндрэлгүй, бөглөрөлгүй /	I 20
38.	Тархины судасны өвчний үлдэц		Аалзан хальсан доорх цус харвалтын үлдэц	I 69.0
39.			Тархины цус харвалтын үлдэц	I 69.1
40.			Гэмтлийн бус гавал доторх бусад цус харвалтын үлдэц	I 69.2
41.			Тархины шигдээсийн үлдэц	I 69.3
42.	Цусны эргэлтийн тогтолцооны бусад онош	36	Шалтгаан тодорхойгүй даралт багасах	I95.0
43.			Ортостатик даралт багасах	I95.1
44.			Архаг гипотензи	I95.8
45.	Шүд ба амны хөндийн өвчин	39	Саатсан ба хоригдмол шүд	K01
46.			Шүдний хатуу эдийн бусад өвчин	K03
47.			Шүдний зөөлц ба сурвалжийн орой тойрны эдийн өвчин	K04
48.			Байрлалын гажиг, зуултын гажиг	K07.3, K07.4
49.			Ам орчмын уйланхай	K09
50.			Шүлсний булчирхайн буглаа, мукоцели	K11.3, K11.6
51.			Стоматит	K12
52.	Ивэрхий	46	Цавины ивэрхий /түгжрэлгүй, үхжилгүй, хүндрэлгүй/	K40.2, K40.9
53.			Гуяны ивэрхий /түгжрэлгүй, үхжилгүй, хүндрэлгүй/	K41.1, K41.9, K41.2
54.			Хүйсний эвэрхий /түгжрэлгүй, үхжилгүй, хүндрэлгүй/	K42.9
55.	Ходоод, гэдэсний шархлаа	47	Ходоодны шархлаа /цус алдалгүй, цооролгүй, хүндрэлгүй/	K25
56.			Дээд гэдэсний шархлаа /цус алдалгүй, цооролгүй, хүндрэлгүй/	K26
57.			Ходоод-өлөн гэдэсний шархлаа /цус алдалгүй, цооролгүй, хүндрэлгүй/	K28

58.			Гастрит ба дуоденит диспепси	K29
59.			Диспепси /биж/	K30
60.	Улаан хоолойн эмгэг	49	Эзофагит, ходоод-улаан хоолойн сөргөө, улаан хоолойн дискинези	K20-K22
61.	Халдварын бус ходоод гэдэсний үрэвсэлт өвчин	52	Кроны өвчин, Шархлаат колит	K50 K51
62.			Халдварт бус гастроэнтерит ба колит	K 52.8, K 52.9
63.			Дивертикулит	K57
64.	Нойр булчир хайн эмгэг	56	Бусад архаг панкреатит	K86.1
65.			Архины шалтгаант архаг панкреатит	K86.0
66.	Элэгний архаг үрэвсэл	58	Архаг гепатит	K73
67.			Элэгний цирроз, элэгний фиброз	K74
68.	Цөсний замын эмгэг	59, 60	Цөсний чулуу	K80
69.			Цөсний хүүдийн архаг үрэвсэл	K82
70.	Хугаралт, мултралт, унах тулах	66	Мөр ба бугалгын хугарал, Дал мөрний үе ба холбоос сунах, тулах ба мултрах	S42-S43
71.			Шууны ясны хугарал, Тохойн үе ба холбоос мултрах, сунах ба чинэрэх	S52-S53
72.			Бугуй ба сарвууны хугарал, Бугуй ба сарвууны үе ба холбоос мултрах, сунах ба чинэрэх	S62-S63
73.			Шилбэний яс шагайн хамт хугарах, Өвдөгний үе ба холбоос мултрах, сунах ба чинэрэх	S82-S83
74.			Шагайнаас бусад тавхайн яс хугарах, Шагай ба тавхайн үе ба холбоос мултрах, сунах ба чинэрэх	S92-S93
75.	Эд эрхтэн өнгөц бэртэх, ил шарх, мэдрэл, судас, шөрмөс бэртэх	65	Толгойн өнгөц гэмтэл, толгойн ил шарх	S00-S01
76.			Мөр ба бугалгын өнгөц гэмтэл, ил шарх	S40-S41,
77.			Мөр ба бугалгын түвшинд мэдрэл, судас, шөрмөс гэмтэх	S44-S46
78.			Тохой ба шууны өнгөц гэмтэл, ил шарх, мэдрэл, судас, шөрмөс гэмтэх,	S50-S56,
79.			Бугуй ба сарвууны өнгөц гэмтэл, ил шарх, мэдрэл, судас, шөрмөс гэмтэх, мултрах, сунах,	S60-S66

80.			Түнх ба гуяны орчмын ил шарх, өнгөц гэмтэл	S70-S71
81.			Өвдөг ба шилбэний өнгөц гэмтэл, ил шарх,	S80-S81,
82.			Шилбэний түвшинд мэдрэл, судас шөрмөс гэмтэх	S84-S86
83.			Биеийн олон хэсгийг хамарсан өнгөц гэмтэл, ил шарх.,	S90-S91,
84.			Шагай ба тавхайн өнгөц гэмтэл, ил шарх, судас, шөрмөс гэмтэх	S94-S96
85.			Биеийн олон хэсгийг хамарсан өнгөц гэмтэл, ил шарх	T00-T01
86.	Остеомиелит яс сийрэгжих, зөөлрөх эмгэг	67	Эмгэг хугаралгүй ясны сийрэгжилт	M81
87.			Насанд хүрэгчдийн яс зөөлрөх	M83
88.			Ясны бүрэн бүтэн байдал алдагдах	M84
89.			Архаг остеомиелит	M86
90.	Артрит, артропати, үе холбох эдийн бусад эмгэг	69	Ийлдэс-ээрэг хэрлэгтөст артрит	M05
91.			Бусад хэрлэг төст артрит	M06
92.			Псориазийн ба гэдэсний эмгэгийн шалтгаант артропати	M07
93.			Өсвөр үеийнхний артрит	M08
94.			Тулай	M10
95.			Өөр бүлэгт ангилсан бусад өвчний үеийн артропати	M14
96.			Артроз	M15-M19
97.			Зангилаат полиартрит ба түүнд хамаарах эмгэг	M30
98.	Арьсны идээт болон меегенцэрт өвчнүүд	72	Стафилококкт цэврүүт арьсны хамшинж	L00
99.			Түүхий	L01
100.			Арьсны буглаа, хатиг ба мундас	L02
101.			Батга, ягаан батга	L70, L71
102.			Бүслүүр үлд	B02,
103.			Арьсны үлд, микоз, кандидоз	B35-B37
104.			Хамуу	B86
105.			Арьсны цэврүүтэх өвчнүүд	73
106.	Бусад акантолизийн эмгэг	L11		
107.	Пемфигойд	L12		
108.	Арьсны бусад цэлцрүүт эмгэг	L13		
109.	Өөр бүлэгт ангилсан өвчний үеийн цэлцрүүт эмгэг	L14		

110.	Харшлын гаралтай арьсны өвчин	74	Атопит дерматит	L20
111.			Хайрст дерматит	L21
112.			Пеленочный дерматит	L22
113.			Хавьтлын харшилт дерматит	L23
114.			Энгийн хавьтлын цочролт дерматит	L24
115.			Гуужимхай [эксофолиатив] дерматит	L26
116.			Дотуур хэрэглэсэн бодисын шалтгаант дерматит	L27
117.			Энгийн архаг ширшил үлд ба маажуур	L28
118.			Загатнаа, бусад дерматит	L29, L30
119.			Гүвдрүү хайрст эмгэг /псориаз/	L40-L45
120.			Чонон хөрвөс ба эритем	L50-L54
121.			Арьс цайх өвчин	L80
122.	Улаан чонон яр	L93		
123.	Арьсны дайврын өвчнүүд	75	Хумсны өвчин	L60
124.			Голомтот халзрал	L63
125.			Сорвижилгүй бусад үс уналт, Сорвижилт халзрал	L65, L66
126.			Хөлсний булчирхайн эмгэг	L74-L75
127.	Арьсны бусад өвчнүүд	76	Флегмона, хумсны халдвар	L03
128.			Арьс ба арьсан доорх эслэгийн фолликулт уйланхай	L72 L81-L99
129.			Нөсөөжих эмгэг	L81
130.			Хайрст кератоз	L82
131.			Арьс харлан зузаарах	L83
132.			Эвэр ба эвэрших	L84
133.			Хэвтрийн холгоос	L89
134.			Өөр бүлэгт ангилаагүй арьс ба арьсан доорх эслэгийн бусад эмгэг	L98
135.			Өөр бүлэгт ангилсан өвчний үеийн арьс ба арьсан доорх эслэгийн бусад эмгэг	L99
136.	Чихрийн шижин, хоол тэжээлийн ба бодисын солилцооны эмгэг	77	Төрөлх иод дутлын хамшинж	E00-E15
137.			Иод дутлаас улбаалсан бамбай булчирхайн эмгэг ба түүнтэй төстэй байдал	
138.			Иод дутлаас улбаалсан эмнэлзүйн шинж тэмдэггүй бамбай булчирхайн дутмагшил	E02
139.			Бусад хордлогогүй бахуу	E04
140.			Бамбай булчирхайн хордлого	E05

141.			Чихрийн шижин /комгүй/	E10-E13
142.	Бөөрний архаг дутмаг шил	81	Архаг уреми /бусад эрхтэн тогтолцооны дутмагшилгүй/	N18
143.	Шээс, бэлгэсийн эрхтэний эмгэг	88	Архаг нефритийн хамшинж	N03
144.			Нефрозын хамшинж	N04
145.			Пиелонефрит, Бөглөрөлт уропати ба сөргөөт уропати	N10- N13
146.			Бөөр ба шээсний замын чулуу	N20 N21
147.			Бөөрний сувганцрын үйл ажиллагааны алдагдлаас үүссэн эмгэг	N25
148.			Шээс ялгаруулах тогтолцооны бусад эмгэг	N30-N39
149.	Эрэгтэйн нехэн үржихүйн эрхтэний эмгэг	91, 92	Түрүү булчирхай томрох	N40
150.			Түрүү булчирхайн үрэвсэлт өвчнүүд	N41
151.			Түрүү булчирхайн чулуу	N42
152.			Хидроцеле	N43
153.			Эрэгтэйн үргүйдэл	N46
154.			Тээрхийн арьс хэт их, фимоз ба парафимоз	N47
155.			Шодойн бусад эмгэг	N48
156.			Эр бэлэг эрхтэний бусад өвчин	N50
157.			Эмэгтэйн нехэн үржихүйн эрхтний эмгэг	94, 97
158.	Бартолины булчирхайн өвчнүүд	N75		
159.	Үтрээ ба оодойн бусад үрэвсэлт өвчин	N76		
160.	Эндомиоз	N80		
161.	Өндгөвч, үр дамжуулах хоолой ба өргөн холбоосны үрэвсэлт бус эмгэг, эм бэлэг эрхтний ур	N83, 84		
162.	Биений юм их хэмжээтэй, ойрхон ба тогтворгүй мөчлөгтэй үзэгдэх	N92		
163.	Эмэгтэйн үргүйдэл	N97		
164.	Хоргүй хавдар ур	99	Ам ба залгиурын хоргүй хавдар	D10-D11
165.			Бүдүүн гэдэс, шулуун гэдэс, хошног ба хошногны сувгийн хоргүй хавдар	D12

166.			Дунд чих, хамрын хөндий ба дайвар хөндийн хоргүй хавдар	D14.0
167.			Өөхөн эдийн хоргүй хавдар	D17
168.			Арьсны бусад хоргүй хавдар	D23
169.			Эр бэлэг эрхтэний хоргүй хавдар	D29
170.	Цусны бүлэгн элтийн эмгэг	100	VIII хүчин зүйлийн удамшлын дутал,	D66,
171.			Харшилт тууралт	D69.0
172.	Цус багадалтын эмгэгүүд	101	Төмөр дутлын цус багадалт	D50
173.			B12 аминдэм дутлын цус багадалт	D51
174.			Фолат дутлаас үүссэн цус багадалт	D52
175.	Түлэгдэлт, хөлдөлт, осгох, оглорол, корризи	104	Мөрний бүслүүр ба дээд мөч, бугуй ба сарвуу халууны ба химийн үйлчлэлээр түлэгдэх (I, II зэрэг)	T22, T23
176.			Түнх, доод мөчний шагай ба тавхайн хэсэг халууны ба химийн үйлчлэлээр түлэгдэх (I, II зэрэг)	T24, T25,
177.			Өнгөц хөлдөлт	T33
178.	Хавдарын эмгэг /зөвхөн туяа хими эмчилгээ/		Уруул, амны хөндий, залгиурын өмөн	C00-C14
179.			Хоол боловсруулах замын эрхтэний өмөн	C15-C26
180.			Амьсгалын ба цээжний эрхтэний өмөн	C30-C39
181.			Яс ба үений мөгөөрсний өмөн	C40-C41
182.			Хөхний өмөн	C50
183.			Эм бэлэг эрхтэний өмөн	C51-C58
184.			Эр бэлэг эрхтэний өмөн	C60-C63
185.			Шээсний замын өмөн	C64-C68
186.			Нүд тархи би төв мэдрэлийн тогтолцооны өмөн	C69-C72
187.			Бамбай булчирхай ба дотоод шүүрлийн булчирхайн өмөн	C73-C75
188.	Халдвартын эмгэг		Сүрьеэ /ДОТС-ын эмчилгээтэй/	A15-A19
189.			Бруцеллөз	A23
190.			Бэлгийн замаар зонхилон дамжих халдвар	A50-A64,
191.			Хламидийн шалтгаант бусад халдвар	A70-A74

192.		Мөөгөнцөртөх [микоз], арьсны үлд, кандидоз,	B35-B37
193.	Сэтгэцийн эмгэг /сэтгэл засал, зөвлөгөө/	Сэтгэц нөлөөт эм, бодисын шалтгаант сэтгэцийн ба зан төрхийн эмгэг /дэмийрэлгүй, солиоролгүй, ойгүйдэлгүй, тэнэгрэлгүй/	F10-F19
194.		Стресттэй холбоотой невротын болон биеийн хэлбэрийн эмгэг	F40-F48
195.		Физиологийн хямрал ба биеийн хүчин зүйлстэй холбоотой зан төрхийн эмгэг	F50- F59
196.		Хүүхэд ба өсвөр насанд эхлэх зан төрхийн болон сэтгэл хөдлөлийн эмгэг	F90-F98

**Нэгдсэн эмнэлэг, БОЭТ, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвд үзүүлэх өдрийн эмчилгээний үйлдлийн жагсаалт**

хүснэгт 3

№	Үйлдлийн нэр	Үйлдлийн код /ICD-9/
	<b>Нүдэнд хийгдэх мэс засал</b>	<b>3</b>
1.	Зовхинд хийгдэх хагалгаанууд	08.0-08.9
2.	Нулимсны тогтолцоонд хийгдэх мэс засал	09.0-09.4
3.	Нулимсны цэг, сувганцрыг сэтгүүрдэх, хамар-нулимсны сувагт гуурс тавих	09.41-09.44
4.	Нүдний салтсад хийх мэс засал	10.0
5.	Нүдний эвэрлэг бүрхэвчид хийх мэс засал	11.0-11.3
6.	Эвэрлэг бүрхэвчийн хугарлын мэс засал /Лазер/	11.7
7.	Солонгон бүрхэвч, өмнөд камерт хийх мэс засал /лазер, коагуляци/	12.1, 12.5, 12.7, 12.9
	<b>Чихэнд хийгдэх мэс засал</b>	<b>4</b>
8.	Гадна чихэнд хийгдэх мэс засал	18.0-18.5
9.	Гадна чихний урагдлыг оёх	18.4

	<b>Хамар, ам залгиурт хийгдэх мэс засал</b>	<b>5</b>
10.	Хамрын цус алдалт тогтоох	21.00-21.09
11.	Хамрын самалдаг тайрах	21.6
12.	Хамрын хугарал засах	21.7
13.	Хамрын дайвар хөндийг угааж соруулах	22.0
14.	Мэс заслын аргаар шүд авах	23.1
15.	Шүдний сурвалжийн орой тайрах, шүдний сувгийн эмчилгээ	23.7
16.	Буйл буюу түүш ясыг зүсэх	24.0
17.	Түүш тэгшлэх, хэлбэржүүлэх	24.5
18.	Гэмтэж бэртсэн шүдийг эрүүнээс авах	24.4
19.	Тагнайд зүслэг хийх	27.1
20.	Эрүү, нүүр орчмын буглаа нэвчдэс нээх	27.0
21.	Гүйлсэн булчирхай болон гүйлсэн булчирхайн эмгэг эдэд зүслэг хийж гоожуурга тавих	28.0
	<b>Амьсгалын эрхтэн тогтолцоонд хийгдэх мэс засал</b>	<b>6</b>
22.	Төвөнхий эд, эмгэг эдийг тайрах, авах	30.0
23.	Төвөнхөд тариа хийх	31.0
24.	Хавирга хооронд сэтгүүрдэж гоожуурга тавих, авах /гуурс/	34.04, 97.4
25.	Нээлттэй бус аргаар /дурангаар/ гуурсан хоолойн эдийн шинжилгээ авах	33.24
	<b>Хоол боловсруулах эрхтэн тогтолцоонд хийгдэх мэс засал</b>	<b>9</b>
26.	Нээлттэй бус аргаар /дурангаар/ улаан хоолойгоос эдийн шинжилгээ авах	42.24
27.	Улаан хоолойн эд, эмгэг эдийг дурангаар авах	42.33
28.	Ходоодонд гуурс тавих	43.1
29.	Ходоодноос дурангаар эдийн шинжилгээ авах	44.14
30.	Дурангаар ходоод, дээд гэдэсний цус алдалтыг тогтоох	44.43

31.	Шулуун гэдэснээс /дурангаар/ битүү аргаар эдийн шинжилгээ авах	48.24
32.	Шулуун гэдэсний эд, эмгэгийг хэсэгчлэн тайрах	48.3-48.36
33.	Хошноого орчмын эдийг зүсэх, тайрах	49.01-49.04
34.	Дурангаар хошногоны эд, эмгэг эдийг тайрах, авах	49.31
35.	Шамбарам өвчний үед хийгдэх ажилбарууд	49.41-49.49
36.	Хошногоны хуниасанд зүслэг хийх	49.5
37.	Элэгнээс битүү аргаар /арьсны гаднаас хатгаж/ /зүүгээр/ эдийн шинжилгээ авах	50.11
38.	Хэвлийн хөндийн дурангаар элэгнээс эдийн шинжилгээ авах	50.14
39.	Хэвлийн хөндийн дурангаар цөсний хүүдийг авах, хэсэгчлэн авах	51.23, 51.24
40.	Ивэрхийг засах /гэдэс гарч хавчигдаагүй, үхжил, хүндрэлгүй/	53.0, 53.2
41.	Хэвлийн хананд зүслэг хийх /гоожуурга тавих/, хүндрэлгүй	54.0
42.	Хэвлийн хөндий, их биед тавьсан эмчилгээний хэрэгслэлийг мэс заслын бус аргаар авах /гуурс, бэхэлгээ, чиг, оёдол/	97.8
	<b>Шээсний замд хийгдэх мэс засал</b>	<b>10</b>
43.	Бөөрний уйланхайг ЭХО хяналтан дор хатгаж соруулж авах	55.01
44.	Бөөрөнд гуурс тавих /рентген брлон ЭХО хяналтан дор/	55.02
45.	Бөөрөнд арьсны гаднаас хатгаж гуурс тавих, бөөрний чулууг дурангаар авах	55.03
46.	Нефростомын гуурсыг сольж тавих	55.93
47.	Пиелостомын гуурсыг сольж тавих	55.94
48.	Арьсны гаднаас хатган давсганд гуурс тавих	57.17
49.	Шээдэг сүвээр давсгийг цэвэрлэх, Давсгнаас чулууг зүсэлт хийхгүйгээр гаргах	57.0
50.	Давсагнаас нээлттэй бус аргаар шээдэг сүвээр дамжуулан эдийн шинжилгээ авах	57.33
51.	Шээдэг сүвний нарийсал арилгах /бөөрний дутагдалгүй/, Шээдэг сүвийг тэлэх/бөөрний дутагдалгүй/	58.5, 58.6
52.	Шээс ялгаруулах эрхтэн, бэлэг эрхтнээс эмчилгээний хэрэгслийг мэс заслын бус аргаар авах /гуур, стент/	97.6, 97.7
	<b>Эр бэлэг эрхтэнд хийгдэх мэс заслууд</b>	<b>11</b>

53.	Түрүү булчирхайг зүсэх	60.0
54.	Түрүү булчирхайгаар хаалттай аргаар/арьсны гаднаас/ хатгаж эдийн шинжилгээ авах	60.11
55.	Үрийн цулцангаас хаалттай аргаар/арьсны гаднаас/ хатгаж эдийн шинжилгээ авах	60.13
56.	Усжсан төмсгөнд /хальсыг/ зүсэх	61.2
57.	Төмсөгний хальсанд хурсан усыг арьсны гаднаас хатгаж соруулж авах	61.91
58.	Арьсны гаднаас хатгаж түрүү булчирхайгаас шингэнийг соруулж авах	60.91
59.	Шодойн хөвчийг таслах	64.0
60.	Тээрхийд арын болон хажуугийн зүслэг хийх	64.91
61.	Шодойд зүслэг хийх, наалдцыг салгах	64.92, 64.93
	<b>Эм бэлэг эрхтэнд хийгдэх мэс заслууд</b>	<b>12</b>
62.	Өндгөвч, умайн гуурсан хоолойн наалдцыг хэвлийн хөндийн дурангаар салгах	65.81
63.	Умайн 2 талын гуурсан хоолойг дурангаар тайрч авах, бөглөх, боох	66.21-66.29
64.	Умайн хүзүүний сувгийг тэлэх	67.0
65.	Умайн хүзүүнд хийгдэх оношилгооны ажилбарууд	67.11, 67.12
66.	Умайн хүзүүг шаантаг хэлбэрээр зүсч авах	67.2
67.	Умайн хүзүүний эмгэг эдийг цахилгаанаар зүсч түлэх, хөлдөөж авах	67.32, 67.33
68.	Умайн хүзүүний уйланхайг авч оёдол тавих /марсупиализаци хийх/	67.31
69.	Умайгаас нээлттэй бус аргаар эдийн шинжилгээ авах /дурангаар/	68.16
70.	Жирэмслэлтийг таслах зорилгоор умайн хөндийг соруулж хусах /эмчилгээний зорилгоор үр хөндөх/	69.51
71.	Умайн хөндийг соруулж цэвэрлэх бусад арга	69.59
72.	Жирэмслэхээс хамгаалах хэрэгсэл /ерөндөг/ умайд байрлуулах	69.70
73.	Зориудаар үр тогтоох	69.92
74.	Үтрээ болон арын хүнхрээнд хийгдэх оношилгооны ажилбарууд	70.2
75.	Бартоллен булчирхайд хийх хагалгаанууд	71.2

	<b>Яс, булчингийн тогтолцоонд хийгдэх мэс засал</b>	<b>14</b>
76.	Яснаас суулгасан багажийг авах шураг, шөрөг авах	78.6
77.	Хугарал, мултралыг засах, /хүндрэлгүй/	79
78.	Үений мултралыг битүү аргаар засах /мэдээгүйжүүлэлттэй/	79.70-79.79
79.	Сарвууны булчин шөрмөс, хальсны эмгэг эдийг авах	82.2, 83.21
80.	Зөөлөн эдээс эдийн шинжилгээ авах	83.21
81.	Сарвууны булчин шөрмөс, хальсыг оёх	82.4
82.	Сарвууны булчин шөрмөсийг шилжүүлэн суулгах / алганы тэнийлгэгч шөрмөс залгах/	82.5
83.	Битүү аргаар дотор бэхэлгээгүйгээр хугарлыг засах /мэдээгүйжүүлэлттэй/	79.0
84.	Арьс, арьсан доорх эдээс шингэн соруулж авах, зүсэх, нээх /буглаа, цусны бүлэн, сийвэн, уйланхай/	86.01, 86.03
85.	Арьс, арьсан доорх эмгэг эдийг хэсэгчлэн тайрах, түлэх, хөлдөөх, электрокогуляци, лазер /ургацаг, хоргүй өөхөн хавдар/	86.3
86.	Арьс, арьсан доорх эдээс эдийн шинжилгээ авах	86.11
87.	Хумс, хумсны суурь болон арьсыг авах, шархыг цэгцлэх	86.23, 86.27
88.	Арьсанд үүссэн хунираа болон соривжилтыг суллах /арьсанд Z зүслэг хийх/	86.84
89.	Хиймэл протез суулгах, тохируулах	84.4
90.	Гөлтгөнө боолт хийх, тулгуур үүсгэх, чиг тавих, даралттай боолт хийх	93.51-93.56
91.	Ясны эмгэгийг эвээр гараар засах эмчилгээ /мултрал/	93.6
92.	Гадны биетийг мэс заслын бус аргаар авах, чулууг зайнаас долгионоор бутлах /чулуу, гадны биет/	98.0-98.5
	<b>Сэтгэцийн өдрийн эмчилгээ</b>	<b>94</b>
93.	Хувь хүний сэтгэл засал эмчилгээ	94.3
94.	Сэтгэл засал эмчилгээ болон зөвлөгөө /бүлгийн эмчилгээ/	94.4
95.	Архи, хар тамхинаас хоргүйжүүлэх, хордлого тайлах, нөхөн сэргээх эмчилгээ	94.6
96.	Архинд донтолт өвчинд зөвлөгөө өгөх сэтгэл засал эмчилгээ	94.46
	<b>Цөмийн эмчилгээ</b>	<b>92</b>

97.	Цацраг идэвхит бодисыг тарих, суулгах /Бамбайн хордлогот бахуу, хавдрыг иод 131-р эмчлэх/	92.28
98.	Цацраг идэвхит зайн эмчилгээ /хорт хавдрын туяа эмчилгээ/	92.23
<b>Сэргээн засах өдрийн эмчилгээ</b>		
99.	Сэргээн засах дасгалууд	93.1
100.	Татлага /гараар болон механик/	93.21
101.	Усан болон дулаан, шарлага эмчилгээ	93.31-93.35
102.	Их биеийн болон бусад татлага /бэхэлгээ, хэрэгсэл ашиглах/	93.4
103.	Хэт ягаан туяаны эмчилгээ, актинотерапи, фототерапи	99.82, 99.83
104.	Хүчилтөрөгч эмчилгээ	93.96
105.	Хэл ярианы эмгэгийг засах дасгал эмчилгээ	93.74
<b>Уламжлалтын өдрийн эмчилгээ</b>		
106.	Зүү эмчилгээ	99.92
107.	Хануур, самнуур /уламжлалтын ангилалыг ашиглана/	-
108.	Төөнүүр /уламжлалтын ангилалыг ашиглана/	-
109.	Эмчилгээний бариа засал /уламжлалтын ангилалыг ашиглана/	-
<b>Мэс заслын бус эмийн болон багажийн эмчилгээ</b>		
110.	Эмнэлгийн мэргэжилтний шууд хяналтанд, курсээр эсвэл схемээр ууж хэрэглэх эм /ДОТС, гормон, бусад эм/	-
111.	Эмнэлгийн нөхцөлд хийх дусал, судас, булчин тариа /зөвхөн эмчлэгч эмчийн заалтаар/	99.1-99.2
112.	Өвдөлт намдаах, хөнгөвчлөх зорилгоор тариа хийх	-
113.	Хавдрын эсрэг хими эмчилгээ	99.25
114.	Гемодиализ	39.95
115.	Хэвлийн гялтангийн диализ	54.98
116.	Эмчилгээний плазмоферез	99.71
117.	Аферез эмчилгээ	99.7
118.	Цус болон цусны бүрдэл хэсгийг сэлбэх (хөнгөн өвчтөнд) /цусны фактор/	99.0

119.	Ион эмчилгээний электрофорез	99.27
120.	Ходоод гэдэсний замын хэрэгслийг мэс заслын бус аргаар суулгах, солих, авах /гуурс, цорго/	97.0, 97.5
121.	Мэс заслын бус аргаар гуурс тавих, угаах	<b>96</b>
122.	Хоол боловсруулах, амьсгалын замд гуурс тавих, угаах, чихээс тавих, хэсгийн эмэн угаалга	96.0, 96.1, 96.3, 96.4
123.	Хоол тэжээлийн бодисыг гэдсээр гуурсаар хийж хооллох	96.6